



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/103

Чойр

Төрийн сангийн үйл ажиллагааны
дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 36 дугаар зүйлийн 36.6, Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам"-ын 3.3, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2024 онд сумдын Санхүүгийн албаны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөөний хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөт хяналт шалгалтыг хууль журмын дагуу зохион байгуулан, үр дүнг танилцуулж, тайланг Сангийн яаманд хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (У.Занабазар)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400239

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 4203 дугаар захирамжийн хавсралт



2024 онд сумдын Санхүүгийн албаны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх хуваарь

| Д/Д | Сумдын төрийн сангийн нэгж | Шалгалт хийх сарууд | | | | | | | | | | | |
|-----|---------------------------------|---------------------|---|---|---|-----|---|---|---|---|----|----|----|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 1 | Сүмбэр сумын Санхүүгийн алба | | | | | | | | | | | | |
| 2 | Шивээговь сумын Санхүүгийн алба | | | | | | | | | | | | |
| 3 | Баянтал сумын Санхүүгийн алба | | | | | №== | | | | | | | |